



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Л.Нямтөмөр
Утас: 261740 Цахим хаяг: nyamtomor@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Анхаарал татахуйц асуудал	13
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ ТАНАА

2022.03.15 № 07/597
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 439,476.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 443,159.6 сая төгрөгөөр, алдагдлыг 3,683.0 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/139 дугаар тушаалаар их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын анхны батлагдсан үнийн дүнд багтаан ангилал хооронд өөрчлөлт оруулан тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 437,207.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 438,671.7 сая төгрөгийн зардал гарган, 1,638.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд цахилгаан эрчим хүч дамжуулах, алдагдлыг багасгах гэсэн 2 зорилтын хүрээнд арга хэмжээг төлөвлөж, эрчим хүч дамжуулах ажлын гүйцэтгэл 108.6 хувьтай, цахилгаан эрчим хүчний алдагдлыг багасгах ажил 0.06 хувь өссөн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Балансын зүйл	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,847,195,040.98	3,704,073,190.52
1.1.2	Дансны авлага	1,423,938,161.69	5,909,972,477.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	856,461,580.11	253,009,130.18
1.1.4	Бусад авлага	809,777,770.48	547,443,628.87
1.1.6	Бараа материал	5,852,236,261.47	5,971,100,848.59
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	86,622,157.43	65,683,779.70
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,876,230,972.16	16,451,283,055.32
1.2.1	Үндсэн хөрөнгө	447,426,690,982.97	467,142,424,952.43
1.2.2	Биет бус хөрөнгө	27,811,201,081.06	27,740,006,876.37
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	837,792,188.68	785,430,176.90
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,466,451,275.26	1,701,273,995.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	477,542,135,527.97	497,369,136,000.70
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	491,418,366,500.13	513,820,419,056.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.5	Богино хугацаат зээл	3,510,597,870.71	428,331,062.40
2.1.1.6	Хүүний өглөг	17,520,922.70	17,261,572.09
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,280,486,003.47	565,161,616.35
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,808,604,796.88	1,010,754,250.84
2.1.2.1	Урт хугацаат зээл	13,866,039,699.38	13,565,536,758.30
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,644,943,847.06	1,817,010,085.40
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	173,922,836,336.25	211,606,780,989.73
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	189,433,819,882.69	226,989,327,833.43
2.2	Өр төлбөрийн нийт дүн	194,242,424,679.57	228,000,082,084.27
2.3.1	Төрийн өмч	238,073,068,351.04	238,073,068,351.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	46,322,418,618.87	46,196,475,124.70
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	27,345,444,720.00	27,011,094,880.50
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(14,564,989,869.35)	(25,460,301,384.49)
2.3.11	Эздийн өмчийн дүн	297,175,941,820.56	285,820,336,971.75
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	491,418,366,500.13	513,820,419,056.02

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	401,765,386,058.25	428,702,066,876.21
2	Борлуулалтын өртөг	397,183,405,296.56	424,772,703,272.96
3	Нийт ашиг (алдагдал)	4,581,980,761.69	3,929,363,603.25

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	Түрээсийн орлого	23,508,727.29	18,004,545.45
5	Хүүгийн орлого	95,547,098.82	3,513,955.42
6	Бусад орлого	9,932,945,112.11	8,483,178,583.24
7	Ерөнхий ба удирдлагын зардал	11,066,915,158.09	11,535,488,507.14
8	Санхүүгийн зардал	254,185,096.75	1,209,562,157.59
9	Бусад зардал	3,282,012,525.16	1,153,544,959.17
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	466,035.29	161,836.41
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(3,315,180.28)	(1.90)
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	28,019,774.92	(1,464,373,102.03)
13	Орлогын татварын зардал	207,094,532.62	173,968,796.28
14	Татварын дараах ашиг (алдагдал)	(179,074,757.70)	(1,638,341,898.31)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(179,074,757.70)	(1,638,341,898.31)
16	Орлогын нийт дүн	(179,074,757.70)	(1,638,341,898.31)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	46,489,466,517.85	28,810,767,698.94	(14,484,251,485.48)	298,889,051,082.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	98,336,373.83	98,336,373.83
Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	46,489,466,517.85	28,810,767,698.94	(14,385,915,111.65)	298,987,387,456.18
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(1,465,322,978.94)	-	(1,465,322,978.94)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(179,074,757.70)	(179,074,757.70)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(167,047,898.98)	-	-	(167,047,898.98)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	46,322,418,618.87	27,345,444,720.00	(14,564,989,869.35)	297,175,941,820.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(9,256,969,616.83)	(9,257,349,704.95)
Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	46,322,418,618.87	27,345,444,720.00	(23,821,959,486.18)	287,918,972,203.73
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(334,349,839.50)	-	(334,349,839.50)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,638,341,898.31)	(1,638,341,898.31)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(125,943,494.17)	-	-	(125,943,494.17)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	46,196,475,124.70	27,011,094,880.50	(25,460,301,384.49)	285,820,336,971.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	114,640,898,115.28	114,339,962,177.45
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	58,821,012,460.63	55,269,059,105.50
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	279,102,880.12	338,670,671.40
1.1.6	Бусад мөнгөн орлого	55,540,782,774.53	58,732,232,400.55
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	112,554,418,468.43	110,440,865,050.63
1.2.1	Ажилагсад төлсөн	25,634,083,135.65	26,560,859,689.09
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,038,029,126.63	8,603,917,239.90
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,451,970,978.91	4,149,915,602.47
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	327,535,825.30	312,168,746.08
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,538,150,020.65	1,099,808,800.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	44,686,660.45	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	58,811,881,108.29	62,106,835,239.40
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	27,394,950.00	53,793,770.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	8,680,686,662.55	7,553,565,963.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,086,479,646.85	3,899,097,126.82
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	95,547,098.82	3,513,955.42
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	95,547,098.82	3,513,955.42
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,384,306,987.45	2,195,249,030.65
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,353,668,622.80	2,192,949,230.65
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,638,364.65	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	2,299,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,288,759,888.63)	(2,191,735,075.23)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,176,083,373.81	46,644,232.45
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,174,733,035.03	46,625,720.42
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	1,350,338.78	18,512.03
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,196,570,258.02	2,897,128,134.50
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	2,188,909,197.59	2,897,111,754.86
3.2.4	Төлсөн ногдол ашиг	7,610,000.00	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	51,060.43	16,379.64
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,979,513,115.79	(2,850,483,902.05)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	777,232,874.01	(1,143,121,850.46)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,069,962,166.97	4,847,195,040.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,847,195,040.98	3,704,073,190.52

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны аудитын тайлангаар		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Дамжуулах ЦЭХ	сая.кВт.ц	6,027.9	6,341.8	6,889.2	547.4
Дамжуулалтын алдагдал	хувиар	3.4	3.5	3.6	0.06
	биетээр	сая.кВт.ц	207.80	224.12	247.7
Дамжуулсан ЦЭХ		5,820.0	6,117.7	6,641.5	523.8
Нийт орлого	сая.төг	411,818.8	439,476.6	437,207.4	(2,269.2)
Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	52,749.3	52,693.4	55,822.6	3,129.2
Оюу толгой ХХК-ийн ЦЭХ худалдан авах гэрээний дагуу тооцсон орлого	сая.төг	349,016.1	376,408.7	372,879.5	(3,529.2)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	10,053.4	10,374.5	8,505.3	(1,869.2)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ:	сая.төг	411,790.7	443,159.6	438,671.7	(4,487.9)
Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	59,488.4	65,135.6	64,638.2	(497.3)
Оюу толгой ХХК-ийн ЦЭХ худалдан авах гэрээний дагуу	сая.төг	349,016.1	376,408.7	372,879.5	(3,529.2)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	3,286.2	1,615.4	1,154.0	(461.4)
Орлогын албан татварын зардал	сая.төг	207.1	-	174.0	174.0
Татварын өмнөх ашиг	сая.төг	28.1	(3,683.0)	(1,464.3)	2,218.7
Орлогын татварын зардал	сая.төг	207.1	-	174	174
Цэвэр ашиг алдагдал	сая.төг	(179.0)	(3,683.0)	(1,638.3)	2,044.7

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдэл, их засвар, хөрөнгө оруулалтын батлагдсан зорилтод түвшин, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Голден пэйж Аудит ХХК-ийн ахлах аудитор Я.Оюун, Ц.Долгормаа, Б.Барбаатар, туслах аудитор Б.Ариунтуяа, аудиторын туслах Ц.Цацрал, Б.Дэжидмаа, Г.Ариун-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Дашням, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлсэн.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Голден пэйж Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/192 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 62,963.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 629.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд гүйцэтгэх үе шатанд 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт зардал 424,772.7 сая төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэх үе шатанд ерөнхий материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт зардал 424,772.7 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 4,247.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн зорилго нь цахилгаан дамжуулах шугам тоноглолын хэвийн, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, тоноглолоор цахилгаан эрчим хүчийг дамжуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 100.0 хувь төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 70.0 хувийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн өмчийн төв байгууллага, 30.0 хувийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж, чөлөөлж, гүйцэтгэх удирдлагыг ТУЗ томилж, чөлөөлж байгаа нь Компанийн тухай хуулийн 62.1.7-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох.”, 75.4-д “... төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.”, 76.1.8-д “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэсэн заалттай нийцэж байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сарын цалин, урамшууллыг 1 хүнд 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь Компанийн тухай хуулийн 62.1.13-д “компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох.”, компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.8 дах заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,847,195.0	3,704,073.1	(1,143,121.8)
Дансны авлага	3,090,177.5	6,710,425.2	3,620,247.7
Бараа материал	5,852,236.2	5,971,100.8	118,864.5
Урьдчилж төлсөн зардал тооцоо	86,622.1	65,683.7	(20,938.3)
Үндсэн хөрөнгө	447,426,690.9	467,142,424.9	19,715,733.9
Биет бус хөрөнгө	27,811,201.0	27,740,006.8	(71,194.2)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	837,792.1	785,430.1	(52,362.0)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,466,451.2	1,701,274.0	234,822.7
Нийт хөрөнгийн дүн	491,418,366.5	513,820,419.0	22,402,052.5
Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,808,604.8	1,010,754.2	(3,797,850.5)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	189,433,819.8	226,989,327.8	37,555,507.9
Эздийн өмчийн дүн	297,175,941.8	285,820,336.9	(11,355,604.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	491,418,366.5	513,820,419.0	22,402,052.5

Касс дахь бэлэн 12.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь харилцах дансанд 3,691.3 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ААНОАТ-ын 0.9 сая төгрөг, НӨАТ-ын авлага 148.1 сая төгрөг байна. Тайлант онд цахилгаан эрчим хүчний авлага 3,620.2 сая төгрөгөөр өссөн байгаа нь системийн хэмжээний авлага бөгөөд энэ нь авлагын өсөлтөнд голлон нөлөөлжээ.

Бусад авлага оны эхний үлдэгдлээс 918.1 сая төгрөгөөр буурсан, үүнээс 253.0 сая төгрөг нь татвар, НДШ-ийн авлага, 785.4 сая төгрөг нь Германы сэргээн босголт зээлийн банкны “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу ДЦС-3 ХК, Дархан ДЦС ХК-д суурилагдсан тоног төхөөрөмжүүдийн зээлийн төлбөр төлөгдсөнтэй холбоотой болно.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 6,683.9 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 36.1 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг нөөцийн аргаар тооцдог байна. Тайлант онд 4.6 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан.

Тайлант онд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн багаж хэрэгсэл нийлүүлэх гэрээт ажлын төлбөрт 45.4 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 86.6 сая төгрөгийн ажил цар тахлаас үүдэлтэйгээр хөл хорио тогтоож, хил гааль хаалттай зэрэг шалтгаанаас дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 54.7 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,971.1 сая төгрөг болж 118.9 сая төгрөгийн өсөлтөд 2021 оны их засвар, техник зохион байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх байсан зарим ажлууд өвлийн их ачааллын үед таслалт, залгалт хийгдээгүйгээс, он дамжихаар болж нөлөөлжээ.

Тайлант онд худалдан авалтаар 8,189.8 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгөөр 34,480.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тайлант онд 6,619.9 сая төгрөгийн худалдан авалт хийж, аваарын нөөцийг бэлэн байлгах зайлшгүй шаардлагатай 118.9 сая төгрөгийн бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 1,572.4 сая төгрөг, их засварын капиталжуулалт 3,196.5 сая төгрөг, техник зохион байгуулалтын ажлаар хийгдсэн 3,380.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгджээ. ТӨБЗГ-ын 2021 оны 439, 440, 544 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 15,300.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 110/10 кВ-ын Хүчит Шонхор дэд станц, 110 кВ-ын 107, 108, 109, 110 дугаарын цахилгаан дамжуулах агаарын шугамын утас, 20,000.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 1.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Спирт бал бурам ХХК-ийн спиртийн үйлдвэрийн цахилгааныг найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд Эрчим сүлжээ ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 110/35/6 кВ-ын Зүүн хараа дэд станцад суурилагдсан тоноглол, 12.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 1.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, нийт 34,400.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 1.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 32,500.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд хүлээн авсан байна.

ТӨБЗГ-ын 2021 оны А-1/683 тоот албан бичиг, 123, 128 дугаар тогтоолоор акталсан 1,067.5 сая төгрөг, ангилал хооронд залруулсан 61,998.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дүн хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 1,701.3 сая төгрөг болж өмнөх оноос 234.8 сая төгрөгөөр өссөн нь их засвар, хөрөнгө оруулалтын ажлуудын хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой.

Биет бус хөрөнгө хорогдлын 71.0 сая төгрөгөөр буурчээ.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд Эрчим хүчний хэмнэлт төслөөр 568.4 сая төгрөг, Германы СБЗБанкны зээлээр хэрэгжсэн 4,838.8 сая төгрөг, Шведийн зээл буцалтгүй тусламжаар 5,718.6 сая төгрөг, Японы улсын засгийн газрын зээлийн хөрөнгөөр 1,198.6 сая төгрөг, дэлхийн банкны 6102 MN төслөөр 880.1 сая төгрөг, УБЦТС ХК-ын Дэлхийн банкны эрчим хүчний төслөөр 361.2 сая төгрөгийн нийт 13,565.5 сая төгрөгийн хийгдсэн ажил бүртгэлтэй байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлд шахмал түлшний үйлдвэр барих барилга угсралтын ажилд шаардлагатай Голомт банкны төслийн зээлийн тайлант онд ногдох өр төлбөр 428.3 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчийн өглөг 565.5 сая төгрөг, хүүний өглөг 17.3 сая төгрөг, нийт 1,010.8 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөр данс 2021 онд 37,555.5 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын буцалтгүй тусламж, улс нийслэлийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан хөрөнгө бүртгэлтэй холбоотой хойшлогдсон орлогын дансны үлдэгдэл өссөн үзүүлэлттэй байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад нийт зардал 26,881.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Оюутолгой ХХК-тай байгуулсан ЦЭХ-ний худалдах, худалдан авах гэрээний дагуу зардал 23,864.4 сая төгрөгөөр, 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу НББОУС-19 “Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөөний бүртгэл”, НББОУС-26 “Тэтгэврийн төлөвлөгөөний нягтлан бодох бүртгэл, тайлагнал”-аар актуар тооцоолол хийж, тэтгэмжийн нөөц сан байгуулсантай холбоотой 898.7 сая төгрөг, тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийн тооцооллоос гарсан хүүгийн зардалд 820.1 сая төгрөгийг бүртгэснээс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өртөг, зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг стандартын дагуу хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, борлуулалт маркетингийн зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих газраар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 439,476.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 443,159.6 сая төгрөгөөр, 3,683.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,629.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна. ЭХС-ын 2021 оны А/139 дугаар тушаалаар ЦДҮС ТӨХК-ийн 2021 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг анхны батлагдсан үнийн дүнд багтаан ангилал хооронд өөрчлөлт оруулан тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 437,207.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 438,671.7 сая төгрөгийн зардал гарган, 1,638.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 тоот тогтоолын дагуу айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбогдуулан айл өрх, зарим аж ахуйн нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөн.

Оюу Толгой ХХК-тай хийсэн цахилгаан эрчим хүчний худалдах, худалдан авах гэрээний дагуу 2021 онд 1,340.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч импортлосон.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоогоогүй байна.

Нийт орлогын гүйцэтгэл 437,207.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,269.2 сая төгрөг буюу 0.5 хувиар тасарсан нь “Оюутолгой” ХХК-тай хийсэн ЦЭХ-ний худалдах, худалдан авах гэрээний дагуу 2021 онд 1,340.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч импортлосон нь төлөвлөснөөс 46.1 сая кВт.цагаар буурч, борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийн хэмжээ 3,529.2 сая төгрөгөөр буурсан нийт орлого буурахад голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 438,671.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,487.9 сая төгрөг буюу 1.0 хувиар буурсан гүйцэтгэлтэй байна. Энэ нь Улс орны эдийн засаг хүндэрч, хэмнэлтийн горимд шилжин ажиллах талаар Монгол Улсын Засгийн газрын 43 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын А-1/354 тоот албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлэх ажлын 9 заалт бүхий төлөвлөгөө батлуулан, зардлын хэтрэлт, хэмнэлтийг сар бүр тооцон гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан нь хэмнэлт гарах нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 480 нэр төрлийн ажилд 8,454.8 сая төгрөгийн зардлыг зарцуулсан байна.

Тайлант онд 3,683.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,638.3 сая төгрөгийн алдагдалтай буюу алдагдлын түвшинг 2,044.7 сая төгрөгөөр буюу 55.5%-иар бууруулсан байна.

ТӨБЗГ-т төрийн өмчийг бусдад түрээслүүлсэн түрээсийн орлогын 40 хувь болох 8.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь тайланд онд нийт 106,817.6 сая төгрөгийн 170 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст илд тод, хугацаандаа мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,789.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 532.6 сая төгрөгийг залруулж, 882.5 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 374.5 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 277.1 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс хэргжилт 80.0 хувийн биелэлттэй байна. Алдаа, зөрчил давтан гарсан 116.6 сая төлбөрийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Анхаарал татахуйц асуудал

Тус компани Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт тусгасны дагуу хэмээн олон төрлийн шагнал урамшуулал давхардуулан олгож байгаа, чиг үүргийн давхардал бий болгож орон

тоо нэмсэн, урт хугацаат зээлийн өр хуримтлагдсан зэрэг эрчим хүчний салбарын хэмжээнд зохицуулах шаардлагатай асуудлуудыг толилуулж байна. Үүнд:

1. Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээг үндэслэн сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулалд сар бүр 50.0 хүртэлх хувиар нийт 4,945.7 сая төгрөг, жилийн үйл ажиллагааны үр дүнг цалинг 2.5 сараар тооцон 2,183.3 сая төгрөг, олгосон. ТУЗ-ийн 2017 оны тогтоолыг үндэслэн 7,129.0 сая төгрөгийн шагналт цалин үр дүнгийн нэмэгдэл давхардуулан олгосон байна.

2. Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр нэрийн дор салбарын тэргүүний нийт 32.9 сая төгрөг олгосон байна.

3. ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 3-ны өдрийн 04 тоот тогтоолоор төслийн нэгж бий болгон, үндсэн үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй, орон тоо чиг үүргийн давхардал бий болгон 10 орон тоо баталж, хөрөнгө зарцуулсан байна.

4. ЦДҮС ТӨХК-ийн 2021 оны үндсэн цалин 15,401.7 сая төгрөг, цалингийн нэмэгдэл, урамшуулал 16,685.5 сая төгрөг байгаа нь үндсэн цалингаас илүү ихээхэн хэмжээгээр шагнал, нэмэгдэл урамшууллыг олгодог байна. Энэ нь үндсэн цалинг үндэслэл муутай тогтоож баталдаг, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээ хэлэлцээр нэрийн дор урамшуулалт цалин, үр дүнг үндсэн цалингаас 108.3 хувиар давуулан олгосон байна. Салбарын дундаж цалин нь урамшуулал нэмэгдэл, үр дүнгийн цалингаас доогуур байна. Үндсэн цалинг зэрэг, хөдөлмөрийн бүтээмжид суурилуулан үндэслэлтэй хариуцлагатай тогтоогоогүйн улмаас эрчим хүчний салбар нэмэгдэл шагнал нэрийн дор сөрөг үр дагаврууд бий болох талтайг Эрчим хүчний яам, ТӨБЗХ, ТУЗ зэрэг эрх бүхий байгууллагууд анхаарах нь зүйтэй.

5. Гүйцэтгэх захирлын цалингийн нэмэгдэл урамшуулал 40.3 сая төгрөгийг 2017 оны ТУЗ-ийн тогтоол, ҮЭХорооны хамтын гэрээ хэлэлцээрийг үндэслэн олгосон байгаа нь эрх зүйн хэм хэмжээ, ажлын үр дүнгийн гэрээтэй нийцээгүй байна.

6. Дамжуулан зээлдүүлэх гэрээ, эрчим хүчний салбарын төсөл хөтөлбөр, гадаадын байгууллагаас авсан зээлийн хүрээнд 9 төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд тайлант онд төсөл, хөтөлбөрийн зээлийн хүүд 1,153.4 сая төгрөг, Анз 854.6 сая төгрөг тус тус төлсөн.

7. ТУЗ-ийн 2012 оны 06 дугаар тогтоолоор ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай журмын дагуу орон байрны нөхцөл сайжруулах зардалд 128.0 сая төгрөг төлсөн.

8. Дэд станцуудад ажиллах ажилчдын байрны нөхцөлийг сайжруулах талаар зорилтот түвшинд тусгагдаагүй ахуйн хэрэглээний ус, ариун цэврийн өрөөний асуудлуудыг шийдвэрлээгүй, шинээр ашиглалтад орсон дэд станцын барилга байгууламжууд чанаргүй стандартын шаардлага хангагдаагүй байна.

9. ЦДҮС ТӨХК нь улс орны ач холбогдол бүхий стратегийн тэргүүлэх эрчим хүчний байгууллага юм. Ажилчдын цалинг хөдөлмөрийн бүтээмжид үндэслэн тогтоох, шинжлэх ухааны оновчтой бодлого, засаглалын удирдлагыг хэрэгжүүлэн, удирдан зохион байгуулах. Хүний эрх дээдлэн, хууль эрх зүйн зарчмаа удирдлага болгон салбарын шинэчлэлт, бүтэц зохион байгуулалт хийж, судалгаа шинжилгээний үндсэн дээр төрийн мэргэшсэн инженерүүдийн ур ухаанч байдлыг дэмжин, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөл, ТӨБЗГ, салбарын яамд анхааран ажиллах цаг болжээ.

Дамжуулан зээлдүүлэх гэрээний үр ашигт байдлыг ханган, төсөл хөтөлбөр хөрөнгө мөнгийг оновчтой ашиглах, ажил үйлчилгээний чиглэл нь ашиг олох, үр дүнтэй байхад чиглэгдсэн, санхүүгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөтэй, хариуцлагыг нэхдэг эзэнтэй, нөхцөл байдлыг зөв төлөвлөдөг, бизнесийн болон хөрөнгө оруулалтын эрсдэлийг оновчтой бодлогоор удирддаг, нийгмийн эрх ашиг стратегийн ач холбогдолтой алсын хараатай бодлого үгүйлэгдэж байгааг анхааралдаа авч ажиллах нь зүйтэй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,874.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,126.3 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 740.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2,874.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 4,247.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанд залруулга хийгээгүй болно.

8.2 Төлбөрийн акт

1. ЭХЯ-ны А/76 тоот тушаалын дагуу эрчим хүчний салбарын ажилчдын шалгалт сургалтанд 1.0 сая төгрөг зарцуулсан боловч анхан шатны хүчин төгөлдөр баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. ТУЗ-ийн зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй 5.2 сая төгрөгийн томилолтын зардлыг ТУЗ-ийн даргад олгож зарцуулсан. Энэ нь нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 11.2-т "Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. ТУЗ-ийн 2021 оны 26 дугаар тогтоолоор Гүйцэтгэх захиралд ногдуулсан сахилгын шийтгэлийн дагуу цалингаас 1.2 сая төгрөгийн суутгал хийгээгүй. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

1. Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 32.3 сая төгрөгийн өр төлбөртэй, 3-аас дээш жилийн насжилттай 12.9 сая төгрөгийн өглөг байна. Үүнд эзэн холбогдогчгүй, татан буугдсан 12.5 сая төгрөг, сураггүй болсон 6.8 сая төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. 2021 оны бизнес төлөвлөгөөнд батлагдаагүй 49.3 сая төгрөгийн барилгыг элементээр задлан үнэлгээ хийх, 67.5 сая төгрөгийн НБББББ боловсруулах гэрээ байгуулсан, Заамарт ажилчдын орон сууц худалдан авах 24.0 сая төгрөг нийт 140.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дугаар тогтоолын 1.1 .. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, ... хуулийн дагуу зарлагдаагүй худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Гүйцэтгэх захиралд сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллыг 50 хүртэл хувиар тооцоолон 29.3 сая, жилийн үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал 11.0 сая нийт 40.3 сая төгрөг олгосон. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Эрчим хүчний сайдын 2021 оны А/22, А/92 тушаалаар батласан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшиний төлөвлөгөөг Эрчим хүчний яамны 2021 оны А/07 тоот тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/727 албан тоот, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 тоот тогтоолоор 1,796,312,328.00 төгрөгөөр өөрчлөлт оруулан зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагат оруулах", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

5. Тайлант онд тендер сонгон шалгаруулалт хийлгүйгээр худалдан авалтын гэрээ байгуулан 116.6 сая төгрөгийн хонь, үхрийн махыг зах зээлийн бодит үнэ цэнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цахим баримтын бүрдүүлэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Бараа материалын 7.2 сая төгрөгийн худалдан авалтын төлбөрийг гүйцэтгэхдээ и-баримтыг бүрдүүлээгүй, цахим и-баримт хуудсанд гүйлгээ хийгдээгүй 84.3 сая төгрөгийн и-баримт илүү шивсэн нийт 91.5 сая төгрөг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа ажил үйлчилгээний худалдан авалтын төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж байх, татварын цахим системд худалдан авалтын баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтыг үйлдэхдээ СЭЗС, ҮСГ-ын 2008 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан хүчингүй болсон маягтаар хөтөлсөн, анхан шатны баримтад байгууллагын нэр, хаяг, гарын үсэг дутуу, цахим төлбөрийн баримтуудыг бөөн дүнгээр бүрдүүлсэн, салбаруудад сар бүр шилжүүлж байгаа санхүүжилтэд захиалгын хуудсууд дутуу байна. Нягтлан бодох бүртгэлд "Интер Актив Би Ай" ХХК-ийн Даймонд программыг ашигладаг бөгөөд тус программ хангамж нь боловсруулалт хийхэд цаг хугацаа их шаарддаг, ерөнхий журналд харилцагчийн нэр байхгүй, харьцсан данс зэрэг гардаггүй, Сангийн сайдын тушаалаар батлагдсан дансны кодчиллол, анхан шатны баримтуудын өөрчлөлтүүд хийгдээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны 347 тоот Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх, анхан шатны маягыг бүртгэх заавар тушаалтай нийцээгүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заалт, Сангийн сайдын 2014 оны 249 тоот Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт тушаалтай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг батлагдсан маягтаар хөтлөх, санхүүгийн программд анхан шатны баримтыг шинэчлүүлэх, журнал боловсруулалт зөв болгох сайжруулалт хийлгэх .

3. Авлагын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 304.2 сая төгрөгийн авлага, 3-аас дээш жилийн насжилттай 36.1 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; гэж заасантай нийцэхгүй байна.

3.1 Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаг байх, олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Их засварын ажлуудыг төрлөөр баталдаг боловч дэд станц тоног төхөөрмжийн паспорт хувийн хэрэгт хөрөнгө оруулалт хийгдсэн ажлын нэрээр, тавигдсан хөрөнгө, засварын ажил бүрээр нь ангилан бүртгэж, албажуулан хувийн хэргийн баяжилт хийж, хөтөлдөггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заалт, Сангийн сайдын 2014 оны 249 тоот Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт тушаалтай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн их засварын ажлуудыг хувийн хэрэгт тухай бүрд хөтлөх, хяналт хэрэгжүүлэх.

5. Цалингийн данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: Ажилчдын цалингаас нийт 316.9 сая төгрөгийн Мобиком, Юнителийн утасны төлбөр, зээлээр авсан гар утасны төлбөр, хамтын сан зэрэг суутгалуудын тооцоолол хийж, санхүүгийн ажилтныг компанийн чиг үүрэгт байхгүй ажлыг гүйцэтгүүлж, ажиллах хүчнийг зохистой удирдлагаар ханган ажиллаагүй. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 зүйлийн 119.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Ажилчдын цалингаас зөвхөн хуульд заасны дагуу суутгалуудыг хийх.

6. Томилолт зардалын данстай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт: Томилолтын зардалд анхан шатны баримтгүй, хүчин төгөлдөр бус баримт бүрдүүлж, нийт 28.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Томилолтын тооцоог хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэж, зардлаар хүлээн зөвшөөрөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	ЭХЯ-ны А/76 тоот тушаалын дагуу ЭХ-ний ажилчдын шалгалт сургалтанд 1.0 сая төгрөг зарцуулсан боловч анхан шатны хүчин төгөлдөр баримтаар нотлогдохгүй байна. Тухайлбал: ЭХЯ-ны ажилтанд томилолт олгосон, Грийн солар инженеринг зочид буудлын 0.4 сая төгрөгийн баримт, шатахууны 0.6 сая төгрөгийн баримт зөрчилтэй. Томилолтын төсөв, тайлан байхгүй. Мөнгөн урьдчилгааны тайланг 9 сарын 30-д гаргасан, тайланг баталгаажуулаагүй.	Улсын төвийн орлого болгох	1	1,000.0			1	1,000.0				
2	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	УЗ-ийн зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй 5.1 сая төгрөгийн томилолтын зардлыг ТУЗ-ийн даргад олгосон	Улсын төвийн орлого болгох	1	5,165.0			1	5,165.0				
3	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	ТУЗ-ийн 2021.11.17-ны өдрийн 26-р тогтоолоор Гүйцэтгэх захиралд ногдуулсан сахилгын шийтгэлийн дагуу цалингаас 1.2 сая төгрөгийн суутгал хийгээгүй. Тогтоол хэрэгжээгүй	Улсын төвийн орлого болгох	1	1,200.0			1	1,200.0				

4	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Тайлант онд 116.6 сая төгрөгийн хонь, үхрийн махны худалдан авалт хийхдээ сонгон шалгаруулалтгүйгээр зах зээлийн бодит үнэ цэнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн.	Бараа, ажил, үйлчилгээг худалдах авах босго үнийн дагуу худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, худалдан авалт хийх	1	116,600.0						1	116,600.0				
5	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	2021 оны бизнес төлөвлөгөөнд батлагдаагүй 49.3 сая төгрөгийн барилгыг элементээр задлан үнэлгээ хийх, 67.5 сая төгрөгийн НБББББ боловсруулах, Заамарт ажилчдын орон сууц худалдан авах 24.0 сая төгрөг нийт 140.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн	Бизнес төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг худалдах авахгүй байх, батлагдсан зорилтот түвшнийг хангаж ажиллах	1	140,847.3						1	140,847.3				
6	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Гүйцэтгэх захиралд сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллыг 50 хүртэл хувиар тооцоолон 29.3 сая, жилийн үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал 11.0 сая нийт 40.3 сая төгрөг олгосон.	Удирдлагын цалин, урамшууллыг ажлын үр дүнтэй уялдуулах	1	40,314.0						1	40,314.0				
7	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 32.3 сая төгрөгийн өр төлбөртэй, 3-аас дээш жилийн насжилттай 12.9 сая төгрөгийн өглөг байна. Үүнд эзэн холбогдогчгүй, татан буугдсан 12.5 сая төгрөг, сураггүй болсон 6.8 сая төгрөгийн өглөгтэй	Эзэн холбогдогчгүй, татан буугдсан байгууллага болон сураггүй болсон хувь хүнд өгөх өр төлбөрийг ТУЗ-өөр шийдвэрлүүлэх	1	32,255.3						1	32,255.3				
8	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Эрчим хүчний сайдын 2021 оны А/22, А/92 тушаалаар баталсан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөг Эрчим хүчний яамны 2021 оны А/07 тоот тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын	Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг эрх мэдлээ хэтрүүлэн өөрчилж байгаа	1	1,796,312.3						1	1,796,312.3				

			газрын 2020 оны А-1/727 албан тоот, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 тоот тогтоолоор 1,796,312,328.00 төгрөгөөр өөрчлөлт оруулан зарцуулсан байна	асуудлыг таслан зогсоох												
9	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Бараа материалын 7.2 сая төгрөгийн худалдан авалтын төлбөрийг гүйцэтгэхдээ и-баримтыг бүрдүүлээгүй, цахим и-баримт хуудсанд гүйлгээ хийгдээгүй 84.3 сая төгрөгийн и-баримт илүү шивсэн нийт 91.5 сая төгрөг байна.	Бараа ажил үйлчилгээний худалдан авалтын төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж байх, татварын цахим системд худалдан авалтын баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх	1	91,500.0									1	91,500.0
10	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Анхан шатны баримтыг үйлдэхдээ СЭЗС, ҮСГ-ын 2008 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан хүчингүй болсон маягтаар хөтөлсөн, анхан шатны баримтад байгууллагын нэр, хаяг, гарын үсэг дутуу, цахим төлбөрийн баримтуудыг бөөн дүнгээр бүрдүүлсэн, салбаруудад сар бүр шилжүүлж байгаа санхүүжилтэд захиалгын хуудсууд дутуу байна. Нягтлан бодох бүртгэлд "Интер Актив Би Ай" ХХК-ийн Даймонд программыг ашигладаг бөгөөд тус программ хангамж нь боловсруулалт хийхэд цаг хугацаа их шаарддаг, ерөнхий журналд харилцагчийн нэр байхгүй, харьцсан данс зэрэг гардаггүй, Сангийн сайдын тушаалаар батлагдсан	Анхан шатны баримтыг батлагдсан маягтаар хөтлөх, санхүүгийн программд анхан шатны баримтыг шинэчлүүлэх, журнал боловсруулалт зөв болгох сайжруулалт хийлгэх	1	-									1	-

			дансны кодчиллол, анхан шатны баримтуудын өөрчлөлтүүд хийгдээгүй.														
11	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Томилолтын зардалд анхан шатны баримтгүй, хүчин төгөлдөр бус баримттай нийт 28.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн.	Томилолтын тооцоог хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэж, зардлаар хүлээн зөвшөөрөх.	1	28,339.1										1	28,339.1
12	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Ажилчдын цалингаас нийт 316.9 сая төгрөгийн Мобиком, Юнителийн утасны төлбөр, зээлээр авсан гар утасны төлбөрийн суутган тооцоолол хийж, санхүүгийн ажилтныг компанийн чиг үүрэгт байхгүй ажлыг гүйцэтгүүлж, ажиллах хүчнийг зохистой удирдлагаар ханган ажиллаагүй.	Ажилчдын цалингаас зөвхөн хуульд заасны дагуу суутгалуудыг хийх	1	316,885.0										1	316,885.0
13	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 304.2 сая төгрөгийн авлага, 3-аас дээш жилийн насжилттай 36.1 сая төгрөгийн авлага байна.	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаг байх, олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх	1	304,161.1										1	304,161.1
14	Царилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	АХГ-2022/94/Н А-СТА-ТӨА	Их засварын ажлуудыг төрлөөр баталдаг боловч дэд станц тоног төхөөрөмжийн паспорт хувийн хэрэгт хөрөнгө оруулалт хийгдсэн ажлын нэрээр, тавигдсан хөрөнгө, засварын ажил бүрээр нь ангилан бүртгэж, албажуулан хувийн хэргийн баяжилт хийж, хөтөлдөггүй байна.	Үндсэн хөрөнгийн их засварын ажлуудыг хувийн хэрэгт тухай бүрд хөтлөх, хяналт хэрэгжүүлэх.	1	-										1	-
ДҮН					14	2,874,579.1	-	-	3	7,365.0	5	2,126,328.9	-	-	6	740,885.2	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 492/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны бизнес төлөвлөгөөнд батлагдаагүй 49,350,000.00 төгрөгийн барилгыг элементээр задлан үнэлгээ хийх, 67,497,320 төгрөгийн НБББББ боловсруулах, Заамарт ажилчдын орон сууц худалдан авах 24,000,000.00 төгрөг нийт 140,847,320 төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 .. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, ... хуулийн дагуу зарлагдаагүй худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/96 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бизнес төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг худалдах авахгүй байх, батлагдсан зорилтот түвшнийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газартирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 491/А0150055
АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сонгон шалгаруулалтгүй, зах зээлийн бодит үнэ цэнээс өндөр үнээр 116,600,000.00 төгрөгийн хонь, үхрийн мах худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1."..Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээг худалдах авах босго үнийн дагуу худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, худалдан авалт хийх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 493/А0150055
АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захиралд үйлдвэрчний хорооны хамтын гэрээ хэлцлийг үндэслэн сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллыг 50 хүртэл хувиар тооцоолон 29,332,800.00 төгрөг, жилийн үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал 10,981,235.00 төгрөг нийт 40,314,035.00 төгрөг олгосон.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Удирдлагын цалин, урамшууллыг ажлын үр дүнтэй уялдуулах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 494/А0150085
АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 32,255,285.00 төгрөгийн өр төлбөртэй, 3-аас дээш жилийн насжилттай 12,932,372.00 төгрөгийн өглөг байна. Үүнд эзэн холбогдогчгүй, татан буугдсан 12,497,913.00 төгрөг, сураггүй болсон хувь хүнд өгөх 6,825,000.00 төгрөгийн өглөгтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эзэн холбогдогчгүй, татан буугдсан байгууллага болон сураггүй болсон хувь хүнд өгөх өр төлбөрийг ТУЗ-өөр шийдвэрлүүлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ
С ОЮУНГЭРЭЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\03\5 Auditin 2 Gazar-170.Docx

0001021335



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 111/А0150055
АХГ-2022/941НА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын А/76 тоот тушаалын дагуу эрчим хүчний ажиллагсдын шалгалт сургалтад 1,000,000.00 төгрөг зарцуулсныг нотлох анхан шатны баримт хүчин төгөлдөр бус байна. Тухайлбал: ЭХЯ-ны ажилтанд томилолт олгосон, Грийн солар инженеринг зочид буудлын 400,000.00 төгрөгийн баримт, шатахууны 600,000.00 төгрөгийн баримт зөрчилтэй, томилолтын төсөв, тайлан байхгүй, мөнгөн урьдчилгааны тайланг гаргаж, тайланг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтаар нотлогдохгүй зардал болох 1,000,000.00 (нэг сая) төгрөгийг, холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт¹ ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 112/10150055

Улаанбаатар хот

АХГ-2022/94/НХ-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 26 дугаар тогтоолоор Гүйцэтгэх захиралд ногдуулсан сахилгын шийтгэл 1,209,600.00 төгрөгийг тооцож, цалингаас суутгал хийгээгүй, тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Сахилгын шийтгэл 1,209,600.00 (нэг сая хоёр зуун есөн мянга зургаан зуу) төгрөгийг цалингаас суутгаагүй, буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
- Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт¹ ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 113/А0150055
АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдлагын зөвлөлийн зардлын төлөвлөгөөнд тусгаагүй 5,165,000.00 төгрөгийн томилолтын зардлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 11.2 "Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан 5,165,000.00 (таван сая нэг зуун жаран таван мянга) төгрөгийн зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт¹ ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭИЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 517/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/94/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний сайдын 2021 оны А/22, А/92 тушаалаар баталсан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг Эрчим хүчний яамны 2021 оны А/07 дугаар дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/727 албан бичиг, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор нийт 1,796,312,328.00 төгрөгийн өөрчлөлт оруулан зарцуулсан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1."..Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг эрх мэдлээ хэтрүүлэн өөрчилж байгаа асуудлыг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, ерөнхий нягтлан бодогч Э.Түмэнжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
С.ОЮУНГЭРЭЛ

